



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 09-аар

Дугаар 1127

Мандалговь


Г Үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлж,¹
нэхэн томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих "АЗДТГ-ын заалнуудад тавилга" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүн иргэний төлөөлөл М.Нандинцэцэг нь гадаадын оронд ажиллахаар явсан мөн үнэлгээний хорооны гишүүн У.Уянга нь жирэмсэний амралттай байгаа тул үнэлгээний хорооноос чөлөөлсүгэй:

Хоёр. Тус үнэлгээний хорооны гишүүнээр аймгийн Төрийн банкны захирал Э.Хөхөөхүү, Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Сүхбаатар нарыг нэхэн томилсугай.

Гурав. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Г.Самданцоодол/-д үүрэг болгосугай.



0200433